

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/160/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>125,198,386.61</u></b>	<b><u>73,331,124.18</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	21,264,798.43	250,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	117,064.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	79,827.43	133,036.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	21,184,971.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	21,134,971.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	50,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	103,933,588.18	73,081,024.18
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,390,900.00	7,625,100.00
35110	Тусгай зориулалттай материал	6,844,400.00	7,081,600.00
35130	Эм боох материал	546,500.00	543,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	96,542,688.18	65,455,924.18
35410	Бичиг хэргийн материал	1,608,609.00	1,399,399.00
35420	Аж ахуйн материал	11,991,779.18	12,505,979.18
35430	Сэлбэг хэрэгсэл	63,000.00	63,000.00
35440	Түлш, шатах тослох материал	965,800.00	77,346.00
35470	Бусад хангамжийн материал	81,913,500.00	51,410,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>366,126,294.15</u></b>	<b><u>350,082,833.23</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	366,126,294.15	350,082,833.23
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	312,356,294.11	270,117,833.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	173,103,726.83	173,103,726.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,355,252.24	-29,583,835.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,965,000.00	34,965,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,868,583.19	-12,364,583.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,278,545.00	113,463,545.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,097,013.23	-81,769,419.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,963,854.45	103,008,447.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,001,392.79	-58,410,730.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,925,445.00	36,925,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,723,002.72	-10,384,729.08
39217	Ном	1,164,967.00	1,164,967.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	53,770,000.04	79,965,000.08
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-679,999.96	-734,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	53,550,000.00	79,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>491,324,680.76</u></b>	<b><u>423,413,957.41</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>491,324,680.76</u></b>	<b><u>423,413,957.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	491,324,680.76	423,413,957.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,718,933.00	94,718,933.00
51101	Өмч: - төрийн	94,718,933.00	94,718,933.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	230,049,661.25	162,138,937.90
51210	Өмнөх үеийн үр дүн	230,049,661.25	230,049,661.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-67,910,723.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,556,086.51	166,556,086.51
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>491,324,680.76</u></b>	<b><u>423,413,957.41</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>626,525,694.00</b>	<b>975,097,002.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,805,951.00</b>	<b>33,749,893.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	41,805,951.00	33,749,893.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,805,951.00	33,749,893.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>122,916,043.00</b>	<b>941,347,109.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	615,265,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	615,265,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	461,803,700.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>108,350,571.00</b>	<b>326,081,709.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	48,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,500,000.00	233,391,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,850,571.00	44,590,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,565,472.00</b>	<b>00.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,565,472.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>623,855,006.61</b>	<b>1,043,007,725.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>623,855,006.61</b>	<b>1,043,007,725.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>596,890,668.87</b>	<b>1,019,648,851.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>128,305,285.00</b>	<b>188,834,961.79</b>
210101	Үндсэн цалин	108,704,252.00	186,579,126.79
210102	Нэмэгдэл	19,601,033.00	1,820,373.00
210104	Урамшуулал	00.00	435,462.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,682,518.83</b>	<b>24,791,742.96</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,535,152.02	17,239,333.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,312,042.80	1,883,964.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,022,752.89	1,514,616.43
210204	Ажилгүйдлийн даатгал	255,687.52	377,620.17
210205	Эрүүл мэндийн даатгал	2,556,883.60	3,776,208.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,579,972.00</b>	<b>14,092,816.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,993,318.00	1,385,828.00
210302	Түлш, халаалт	10,586,854.00	11,111,428.00
210303	Цэвэр, бохир ус	999,800.00	1,595,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,168,446.51</b>	<b>52,438,539.00</b>
210401	Бичиг хэрэг	2,662,860.00	1,426,410.00
210402	Тээвэр, шатахуун	10,683,793.51	48,549,377.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	651,793.00	1,646,252.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	266,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>7,766,050.00</b>
210502	Хоол, хүнс	00.00	7,766,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>985,500.00</b>	<b>26,887,220.00</b>
210604	Урсгал засвар	985,500.00	26,887,220.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>488,600.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	488,600.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>855,900.00</b>	<b>651,014,468.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	650,034,968.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,600.00	210,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	63,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,300.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	474,000.00
210807	Газрын төлбөр	155,000.00	155,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>416,824,446.53</b>	<b>53,823,053.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	372,402,165.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,371,800.00	2,300,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,050,481.53	51,523,053.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,964,337.74</b>	<b>23,358,873.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,124,800.00</b>	<b>9,533,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,124,800.00	9,533,700.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,839,537.74</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,839,537.74	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>13,825,173.68</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	13,825,173.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,670,687.39</b>	<b>-67,910,723.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,670,687.39</b>	<b>-67,910,723.35</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>584,719,743.00</b>	<b>941,347,109.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>584,719,743.00</b>	<b>941,347,109.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	615,265,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	615,265,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	461,803,700.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>108,350,571.00</b>	<b>326,081,709.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	48,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,500,000.00	233,391,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,850,571.00	44,590,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,565,472.00</b>	<b>00.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,565,472.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>584,719,743.00</b>	<b>935,302,516.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>584,719,743.00</b>	<b>935,302,516.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>536,620,434.26</b>	<b>911,943,642.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>127,859,698.00</b>	<b>188,947,984.79</b>
210101	Үндсэн цалин	108,258,665.00	146,570,277.68
210102	Нэмэгдэл	19,601,033.00	27,588,513.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,202,995.53
210104	Урамшуулал	00.00	7,586,197.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,138,864.26</b>	<b>24,214,262.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,999,897.45	16,551,075.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,303,642.80	2,001,202.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,022,752.89	1,512,893.64
210204	Ажилгүйдлийн даатгал	255,687.52	377,189.74
210205	Эрүүл мэндийн даатгал	2,556,883.60	3,771,901.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,579,972.00</b>	<b>14,092,816.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,993,318.00	1,385,828.00
210302	Түлш, халаалт	10,586,854.00	11,111,428.00
210303	Цэвэр, бохир ус	999,800.00	1,595,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,477,200.00</b>	<b>4,339,252.00</b>
210401	Бичиг хэрэг	1,683,000.00	951,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,192,300.00	1,542,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	431,900.00	896,252.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>985,500.00</b>	<b>180,000.00</b>
210604	Урсгал засвар	985,500.00	180,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>488,600.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	488,600.00	00.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,527,900.00	677,669,327.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,672,000.00	676,689,827.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,600.00	210,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	63,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,300.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	474,000.00
210807	Газрын төлбөр	155,000.00	155,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,562,700.00	2,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	347,190,900.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,371,800.00	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,099,308.74	23,358,873.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,124,800.00	9,533,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,124,800.00	9,533,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,839,537.74	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,839,537.74	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,134,971.00	13,825,173.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	13,825,173.68
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	21,134,971.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	6,044,593.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	6,044,593.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	6,044,593.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	6,044,593.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,044,593.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-6,044,593.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,024,563.86	488,653,993.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	354,410.00	354,410.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,378,973.86	489,008,403.37
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,670,687.39	2,670,687.39
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,556,086.51	230,049,661.25	491,324,680.76
D01	2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,556,086.51	230,049,661.25	491,324,680.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,556,086.51	230,049,661.25	491,324,680.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-67,910,723.35	-67,910,723.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,556,086.51	162,138,937.90	423,413,957.41

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	615,265,400.00	601,447,994.32	13,817,405.68	97.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	615,265,400.00	601,447,994.32	13,817,405.68	97.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	605,731,700.00	591,914,294.32	13,817,405.68	97.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	199,997,100.00	188,947,984.79	11,049,115.21	94.5
210101	Үндсэн цалин	163,070,700.00	146,570,277.68	16,500,422.32	89.9
210102	Нэмэгдэл	25,310,400.00	27,588,513.78	-2,278,113.78	109.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,616,000.00	7,202,995.53	4,413,004.47	62.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,999,700.00	24,214,262.53	785,437.47	96.9
210201	Тэтгэврийн даатгал	17,291,300.00	16,551,075.64	740,224.36	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,927,100.00	2,001,202.38	-74,102.38	103.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,541,700.00	1,512,893.64	28,806.36	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	385,400.00	377,189.74	8,210.26	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	3,854,200.00	3,771,901.13	82,298.87	97.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,900,100.00	14,092,816.00	807,284.00	94.6
210301	Гэрэл, цахилгаан	1,849,800.00	1,385,828.00	463,972.00	74.9
210302	Түлш, халаалт	11,368,900.00	11,111,428.00	257,472.00	97.7
210303	Цэвэр, бохир ус	1,681,400.00	1,595,560.00	85,840.00	94.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,474,700.00	4,339,252.00	135,448.00	97.0
210401	Бичиг хэрэг	1,003,300.00	951,000.00	52,300.00	94.8
210402	Тээвэр, шатахуун	1,605,300.00	1,542,000.00	63,300.00	96.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	907,800.00	896,252.00	11,548.00	98.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	550,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	408,300.00	400,000.00	8,300.00	98.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	192,300.00	180,000.00	12,300.00	93.6
210604	Урсгал засвар	192,300.00	180,000.00	12,300.00	93.6
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	210,100.00	00.00	210,100.00	-
210702	Дотоод албан томилолт	210,100.00	00.00	210,100.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	358,390,600.00	357,639,979.00	750,621.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,951,800.00	356,660,479.00	291,321.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,100.00	210,000.00	100.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	63,000.00	63,000.00	0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,300.00	77,500.00	1,800.00	97.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,300.00	00.00	3,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	928,100.00	474,000.00	454,100.00	51.1
210807	Газрын төлбөр	155,000.00	155,000.00	0	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2567100.00	2500000.00	67,100.00	97.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,567,100.00	2,500,000.00	67,100.00	97.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9533700.00	9533700.00	0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,533,700.00	9,533,700.00	0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,533,700.00	9,533,700.00	0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	615,265,400.00	601,447,994.32	13,817,405.68	97.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	615,265,400.00	601,447,994.32	13,817,405.68	97.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	615,265,400.00	601,447,994.32	13,817,405.68	97.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	21.00	2	91.3
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	09.00	2	81.8
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0	100.0
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	0	#DIV/0!
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	21.00	2	91.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.00	10.00	2	83.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>326,073,941.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>326,073,941.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	326,073,941.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	326,073,941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	326,073,941.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	326073941.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	326,073,941.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	233,391,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,582,232.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь "Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжих таатай орчин бий болгох" эрхэм зорилготой тус байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу баталсан бүтцийн төрийн захиргааны 10, төрийн үйлчилгээний 11, нийт 21 орон тоотой үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Н.Мэндбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Батнасан нар зурж, нярваар 2022 оны 1-3 сард Э.Самбуу, 4-11 дүгээр сард Ц.Ганбат ажиллаж, ажлаас гарч 12 дугаар сард бичиг хэргийн ажилтан Д.Мөнгөнтуул нярвын ажлыг хавсран гүйцэтгэжээ.

Өмнөх онуудад Баянхонгор аймгийн ГБХЗХГ тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжиж байсныг 2022 оноос улсын төсвөөс санхүүжүүлж, Төрийн сан дахь дансыг өөрчилсөн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, НББ-ийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Гэр бүлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Татварын багц хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23,27 хамтарсан тушаалаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ийг мөрдсөн;
- Хөдөлмөр нийгмийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/110 тоот тушаалаар Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар баталсан;
- Соёл, урлагын газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 тоот тушаалаар "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" журмыг баталсан;
- Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 386 дугаар тогтоолоор төрийн захиргааны зарим албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан;
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;

- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй ГХБЗХГ-ийн даргын 2021.01.05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,910.84 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	21,264.8	250.1	(21,014.7)
Бараа материал	103,933.6	73,081.0	(30,852.6)
Үндсэн хөрөнгө	366,126.3	350,082.8	(16,043.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>633,049.9</b>	<b>616,162.2</b>	<b>(16,887.7)</b>
Өр төлбөр	-	-	-

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	491,324.7	423,413.9	(67,910.8)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>491,324.7</b>	<b>423,413.9</b>	<b>(67,910.8)</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын залруулсан санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Өмнөх онд өндөр настны тэтгэвэрт гарах нэг хүний тэтгэмжийн 21,264.8 мянган төгрөгийг 2021 оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлэн авлагаар бүртгэснийг 2022 онд харилцах дансанд орж, 2022 оны 3 дугаар сард тус ажилтан өндөр настны тэтгэвэрт гарснаар тус авлага барагдсан байна.

Оны эцэс дэх 250.1 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын авлага байна.

“Хамтдаа шийдье” төслийн хүрээнд өмнөх онд бэлтгэсэн 30,806.7 мянган төгрөгийн гарын авлага, өврийн багцыг тайлант онд 20 сумын 105 багт ажиллаж зарцуулснаас бараа материал буурсан үзүүлэлттэй байна.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар үндсэн хөрөнгө актлаагүй, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас суурин компьютер үнэ төлбөргүй шилжүүлснийг бүртгэж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн улсын үзлэг тооллогоор тус газарт гэрчилгээ олгогдоогүй байсан газарт гэрчилгээ авч тухайн газрыг бүртгэлд тусган, НҮБ-ийн санхүүжилтээр 5,000.0 мянган төгрөгийн 2 ширхэг зөөврийн компьютер, 1,044.6 мянган төгрөгийн ширээ сандлыг худалдан авснаар үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 67,910.7 мянган төгрөгөөр буурч, 162,138.9 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар улсын төсвөөс авах санхүүжилт санхүүжилт өмнөх оноос 138,717.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 615,265.4 мянган төгрөг болсон ба санхүүжилтийг бүрэн авч, үйл ажиллагаандаа батлагдсан төсвийн 97.8 хувь буюу 601,447.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 13,817.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 67,10.7 мянган төгрөгөөр буурч 423,413.9 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 896,189.4 мянган төгрөг авахаар төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 264,566.4 мянган төгрөгөөр бууруулж, 631,622.9 мянган төгрөгөөр баталсан нь тухайн жилд шинээр хуримын ордон

ашиглалтад орохоор тооцоолж төсвийн төслөө хийсэн боловч барилга ашиглалтад ороогүйгээс тогтмол зардал хасагдсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас 2022 оны 2 дугаар сард 32,600.4 мянга, 5 дугаар сард 29,017.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 12 дугаар сард 24,700.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 615,265.4 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс олгохоор батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 97.8 хувь буюу 601,447.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 13,817.4 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97.8 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

			/мянган төгрөгөөр/		
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ХӨТӨЛБӨР 72207-ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	586,355.3	572,765.4	13,589.9	97.7%
1.1	АРГА ХЭМЖЭЭ 80101 -Эрсдэлийн болон НБҮ хийх	248,779.9	235,253.8	13,526.1	94.6%
1.2	АРГА ХЭМЖЭЭ 80236 –Ажил олгогчоос тэтгэмж	5,041.7	5,002.5	39.2	99.2%
1.3	АРГА ХЭМЖЭЭ 80237 – Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	220,000.0	219,999.2	0.8	100.0%
1.4	АРГА ХЭМЖЭЭ 80238 – Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	103,000.0	102,976.1	23.9	100.0%
1.5	АРГА ХЭМЖЭЭ 80802 – Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,533.7	9,533.7	0.0	100.0%
2	ХӨТӨЛБӨР 72209-ЗАЛУУЧУУД БОЛОН ОЮУТНУУД	20,338.9	20,284.6	54.3	99.7%
2.1	АРГА ХЭМЖЭЭ 83115– Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөл	20,338.9	20,284.6	54.3	99.7%
3	ХӨТӨЛБӨР 72212-ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	8,571.2	8,398.0	173.2	98.0%
	Дүн	615,265.4	601,448.0	13,817.4	97.8%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагад НҮБ, ГБХЗХГ, хүүхэд харах үйлчилгээ, “Өвгөн жаргалант” хүүхдийн зуслангийн орлогоор нийт 326,396.7 мянган төгрөг орсныг зарцуулсан байна.

Байгууллагын даргын 2022.06.13-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Хүүхдийн “Өвгөн жаргалант” зуслангийн үйл ажиллагааг 2022.06.15-2022.08.15-ны хугацаанд ажиллуулж, даргын А/45 дугаар тушаалаар хүүхдийн нэг өдрийн үнийн тарифыг 25.0

мянга, насанд хүрэгчдийн үнийн тарифыг 50.0 мянган төгрөгөөр тогтоож, тайланд онд 44,905.0 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.01.04-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 615,265.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,228.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,460.3 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, сургалтад оролцсон томилолтын зардал авсан албан хаагчдад хоолны зардлыг давхардуулан олгосон зөрчил илэрсэнд аудитаар төлбөрийн акт тогтоов.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 875,018.0 мянган төгрөгийн 54 гүйлгээ, зарлагын 346,132.1 мянган төгрөгийн 38 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 178,356.4 мянган төгрөгийн 66 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,950.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 30,031.3 мянган төгрөгийн 6 шийдвэр, тайлант онд бусад аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн 226,805.6 мянган төгрөгийн 34 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаас мэдээлээгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, 117,386.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, менежментийн захидлаар 22,846.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	117,386.9	1	117,386.9	50.0
Зөвлөмж	5	22,846.0	5	22,846.0	100.0
Нийт дүн	6	140,232.9	6	140,232.9	75.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ГБХЗХГ-ын 2022.05.30-ны өдрийн 280 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.30-ны өдрийн 280 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна. Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил давтагдсан тул хэрэгжилтийг 75 хувиар тооцсон болно.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн Хүүхдийн “Өвгөнжаргалт” зуслангийн 60 жилийн ойг 2022.08.25-2022.08.27-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн ба санхүүгийн тайлангийн аудитаар ойтой холбоотой асуудлыг авч үзээгүй тул Төрийн аудитын байгууллагын анхаарах асуудлын хүрээнд энэ асуудлыг тодруулан шалгах нь зүйтэй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 500.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

НҮБ-ийн "Үе тэнгийнхний дээрэлхэлт хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх" төслийн хүрээнд батлагдсан хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөгөөр явуулын сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд ашиглах зөөврийн компьютерын үнээс суутган тооцсон хувь хүний орлогын албан татварт 500.0 мянган төгрөгийг суутган тооцсон атлаа үндсэн хөрөнгөд бүртгэхдээ 4,500.0 мянган төгрөгөөр бүртгэж үндсэн хөрөнгийн анхны өртгийг буруу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 23,159.3 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрснээс 4,268.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 13,311.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5,580.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын төсвийн захирагчид илүү цагийн хөлсөнд 2022 оны 6-7 дугаар сард 719.9 мянган төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон, 2022 оны 6 дугаар сард ажилд орсон 3 албан хаагчийн ажилласан өдрийг 1 хоногоор илүү тооцсоноос 27.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн тул 747.8 мянган төгрөгийг холбогдох албан хаагчдаар нөхөн төлүүлж, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар албан томилолтын хуудасгүй, томилолтын хуудаст ажилласан хугацааны тэмдэглэлийг бичээгүй байхад 1,900.5 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 дэх “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, заалтыг зөрчсөн тул төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. "Гэр бүл, хамьдаа хамгаалал хамтдаа", "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн"-д оролцсон 9 сумын албан хаагч өөрийн байгууллагаасаа томилолтын зардал авсан байхад Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас эдгээр албан хаагчдад хоолны зардалд төсвөөс 1,620,000 төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно” гэснийг зөрчсөн тул байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1. Хүүхдийн “Өвгөн жаргалант” зуслангийн гадна талын хашаа, төв хаалгыг барихаар 2022 онд зуслангийн орлогоос нийт 13,311.0 мянган төгрөгийн материал авч, албан хаагчдын хүчээр барьж, ажлыг бүрэн дуусаагүй байхад материалыг зарлага болгон данснаас хассан ба нягтлан бодогч бараа материалын Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хөрөнгийг бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байгаа тул хаалга, хашааг бүрэн барьж дуусган, хөрөнгийг хүлээн авах комисс томилж, хүлээн авсан актыг үйлдэж, хөрөнгөд орлогод авах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст "Банхар" төслийн сургалт санхүүжилтийн 18,950.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 30,031.3 мянган төгрөгийн 6 хөрөнгө зарцуулах тушаалыг мэдээлээгүй, тайлант онд 34 байгууллагатай 226,805.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсныг байршуулаагүй ба өмнөх онд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг өгсөн байхад бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил дахин давтагдсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэснийг зөрчсөн байгаа тул албан шаардлагыг шийдвэрлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хариуцлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын нягтлан бодогч өөрийн хамаарал бүхий иргэн Л.Бүрнээгийн дансанд 2022 онд 2 удаагийн шилжүүлгээр 5,580.0 мянган төгрөгийг шилжүүлж, 2 ширхэг зөөврийн компьютер, Банхар төслийн 100 ширхэг малгайг худалдан авч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг зөрчсөн байна. хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу зарцуулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих удирдлагын хяналтыг сайжруулах, цаашид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан байгууллагын нягтлан бодогчид талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Батлагдсан хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөгөөр зөөврийн компьютерын худалдан авч, хувь хүний орлогын албан татварт 500.0 мянган төгрөгийг суутган тооцсон атлаа үндсэн хөрөнгөд бүртгэхдээ 4,500.0 мянган төгрөгөөр бүртгэж үндсэн хөрөнгийн анхны өртгийг буруу илэрхийлсэн байна.	1	500	0	0	1	500.0	1	500.0				
Дүн	1	500.0	0	0	1	500.0	1	500.0	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын нягтлан бодогч өөрийн хамаарал бүхий иргэн Л.Бүрнээгийн дансанд 2022 онд 2 удаагийн шилжүүлгээр 5,580.0 мянган төгрөгийг шилжүүлж, 2 ширхэг зөөврийн компьютер, Банхар төслийн 100 ширхэг малгайг худалдан авч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг зөрчсөн байна.	1	5,580.0					1	5,580.0				
Байгууллагын даргад илүү цагийн хөлсөнд 1,719.9 мянган төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон, 3 албан хаагчийн ажилласан өдрийн 1 хоногоор илүү тооцсоноос 27.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	747.8	1	747.8								
Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар албан томилолтын хуудасгүй, томилолтын хуудаст ажилласан	1	1,900.5	1	1,900.5								

хугацааны тэмдэглэлийг бичээгүй байхад албан томилолтын зардлыг олгосон байна.												
Хүүхдийн "Өвгөн жаргалант" зуслангийн гадна талын хашаа, төв хаалгыг барихаар 2022 онд зуслангийн орлогоос нийт 13,311.0 мянган төгрөгийн материал авч, албан хаагчдын хүчээр барьж, ажлыг бүрэн дуусаагүй байхад материалыг зарлага болгон данснаас хассан ба нягтлан бодогч бараа материалын Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хөрөнгийг бүртгээгүй байна.	1	13311.0			1	13,311.0						
Дүн	4	21,539.3	2	2,648.3	1	13,311.0	1	5,580.0	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст "Банхар" төслийн сургалт санхүүжилтийн 18,950.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 30,031.3 мянган төгрөгийн 6 хөрөнгө зарцуулах тушаалыг мэдээлээгүй, тайлант онд 34 байгууллагатай 226,805.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсныг байршуулаагүй байна.	1	0			1	0		0
Дүн	1	0	0	0	1	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
"Гэр бүл, хүүхэд хамгаалал хамтдаа", "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн"-д оролцсон 9 сумын албан хаагч өөрийн байгууллагаасаа томилолтын зардал авсан байхад Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас эдгээр албан хаагчдад хоолны зардалд төсвөөс 1,620,000 төгрөгийг давхардуулан олгосон байна.	1	1,620.0	1	1,620.0				
Дүн	1	1,620.0	1	1,620.0	0	0	0	0
Нийт дүн	2	1,620.0	1	1,620.0	1	0	0	0

---oOo---